

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2020 оны 12 дугаар сарын 01


Багануур дүүрэг

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2020 онд хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /эх үүсвэр/	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээ
НЭГ.ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН ХОТ								
Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:								
18	1.10. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг эрчимжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	БҮТП ОНӨТҮГ, ДБҮҮХ	100	100
<ul style="list-style-type: none"> • 2019 онд НЗДТГ болон ЭХЯ-д тус тус хүргүүлсэн, 2020 онд БҮТП-ийн Ерөнхий цахилгаан хангамжийн 7,3 км урт 110 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугам /ЦДӨХАШ/-ыг дэд станцын хамт байгуулах 9,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудлыг холбогдох газрууд 2021 он хүртэл хойшлуулахаар шийдвэрлэсэн. • Батлагдсан зураг төслийн техникийн нөхцөлөөр БҮТП-д 220 кВ-ын дэд станц байгуулахаар тусгаж, нийт хэрэгцээний 63 МВт эрчим хүчийг 2024 оноос Багануур Повер ХХК-ийн Цахилгаан дулааны станцаас хангахаар төлөвлөсөн байв. • 2024 он хүртэл паркийн бүтээн байгуулалтыг тасралтгүй хөгжүүлэх, зарим тэргүүлэх төслүүдийг эхлүүлэх шаардлагатай учраас Паркийн удирдлага ЭХЯ болон ЦДҮС ТӨХК-тай уулзалт зохион байгуулж, Багануур-220 дэд станцаас 110 кВ-ын шугамаар авч болох эрчим хүчний нөөц, боломжуудыг хайж хамтран ажилласны үр дүнд 8-14 МВт эрчим хүчийг эхний ээлжинд 110 кВ-ын шугамаар авах боломжыг бүрдүүлж ажиллав. • Мөн хувийн хэвшлийн байгууллагад танилцуулж ажилласнаар Багануурт төмрийн үйлдвэрийн төсөл хэрэгжүүлж буй “МЕСЕС” ХХК-тай хамтран ажиллах үр дүнд хүрсэн. Тус компанийн төслийн байршил нь паркийн Хөнгөн болон хүнд үйлдвэрийн бүсийн дунд зэргэлдээ байршилтай учраас нэгдсэн цахилгаан хангамжийн 7,3 км шугамыг 2 хэлхээтэй 1 тулгууртай байгуулж, паркийн эзэмшилд шилжүүлэх, хөрөнгө оруулалтын 50%-ийг хариуцах, өөрийн эзэмшлийн талбайгаас паркийн 110/35/10-ын дэд станц барих газар эзэмшүүлэхээр шилжүүлэн өгөх зэрэг хоёр талдаа харилцан ашигтай санал ирүүлснийг 2 дугаар сард НЗД бгөөд УБ хотын 								

		<p>захирагч С.Амарсайхан болон Багануур дүүргийн засаг дарга Ц.Сандаг очир нарт танилцуулан үүрэг чиглэл авч өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг гүйцэтгэгч “Мон-Энержи Консалт” ХХК нь ЭХЯ-наас 07 дугаар сарын 30-ны өдөр олгосон “БҮТП болон Төмрийн үйлдвэрийн эрчим хүчний нэгдсэн ерөнхий цахилгаан хангамж”-ын 51/2020/87 тоот дугаартай Техникийн нөхцөл болон 09 дүгээр сарын 16-ны өдөр олгосон “Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах №2020/Ц-61 дугаартай даалгаврын” дагуу ЦДӨХАШ-ын урьдчилсан трассын шугамын зургийг боловсруулж, ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөн зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж байна. 2. Мөн Гүйцэтгэгч нь зургийн ажлын дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний Зүүн өмнөд бүсийн салбарын ТӨХК болон БҮТП-тай 2020 оны 10 дугаар 28-ны өдөр гурвалсан уулзалт хийж, 220/110/35 кВ-ын Багануур дэд станц дээр очиж шинээр холбогдох дэд станцын гаргалгаа болон удирдлага тоноглолыг байршуулах талаар зөвшилцөн хэмжилтийн ажлыг гүйцэтгэлээ. 3. 7,3 км шугамыг барих ажлыг “МЕСЕС” ХХК нь геологийн судалгааны ажлаас эхлүүлсэн бөгөөд Ковид-19 цар тахалтай тэмцэх үндэсний хэмжээний үйл ажиллагааны улмаас түр зогсоосон байна. <p>Багануур дүүргийн ЭЗН-ийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилтуудыг улс, нийслэлийн эдийн засаг, төсвийн онц хүндрэлтэй, мөн дэлхийн хэмжээний цар тахлын үед урт хугацаанд үргэлжилж буй хорио цээрийн дэглэмийн цаг үед хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг олох, нөөц боломжуудыг нээж судлах, их хэмжээний зардлуудыг багасгах хэмнэх, оновчтой арга хэмжээнүүдийг зохион байгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж багагүй хүчин чармайлт тавин дээр дурьдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд цаашид үргэлжлүүлэн зорьсон үр дүнд хүргэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Батлагдсан зураг төслөөр БҮТП-ийн “Хүнд үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалт”-нд шаардлагатай 28,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудалыг 2019 онд Багануур дүүргийн ЗДТГ, НЗДТГ, УУХҮЯ, ЭХЯ, БХБЯ-дад тус тус хүргүүлсэн. • Нийслэл болон Дүүргийн ЭЗН-ийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулсан санхүүжүүлэлтүүд Улсын төсөв, эдийн засаг маш хүнд байгаа энэ цаг үед шийдвэрлэгдээгүй. • Хүнд үйлдвэрлэлийн бүс /ХҮБ/-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын зардлыг бууруулах, цаг хугацааг хэмнэх үүднээс Багануур ХК-ийн одоогоор ашиглалтгүй байгаа (“Породная станция”) төмөр замын хөрс тээвэрлэлтийн станцын барилга байгууламж, дэд бүтцийг ашиглах боломж байгааг судлан саналаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулсан. • Багануур ХК-ийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй тайлант онд хамтран ажиллах, мэдээлэл солилцох чиглэлээр 2 удаагийн уулзалтыг зохион байгуулан, шаардлагатай техникийн өгөгдөл мэдээллүүдийг хүлээн авч, дараах үндсэн хоёр чиглэлээр төсөл боловсруулахаар ажиллаж байна. <ol style="list-style-type: none"> 1. Багануур ХК-ийн дээрх байгууламжийг дараах зориулалтаар ашиглах боломжтой. Үүнд: <ul style="list-style-type: none"> • <i>Дулаан, цэвэр ус, бохир усны дэд бүтцийг ХҮБ-ийн хэрэгцээнд ашиглах /Багануур ДС-аас ХҮБ хүртэл шууд холбогдсон/</i> 	
--	--	---	--

		<ul style="list-style-type: none"> • “Галуут” 110 кВ-ын дэд станцыг ХҮБ-ийн цахилгаан эрчим хүчний хангамжинд ашиглах /ХҮБ-ийн талбайгаас 100м-т байршилтай/ • Төмөр замыг ашиглах /ХҮБ-ийн 2 талбайн дундуур хөндлөн гарч БР-УБ төмөр замд шууд холбогдсон/ • Захиргааны барилгыг Паркийн нэгжүүд болон ХҮБ-ийн нийтийн үйлчилгээний зориулалтаар /ХҮБ-ийн талбайн дэргэд байршилтай/ тус тус ашиглах <p>2. Багануур ХК-ийн дээрх байгууламжийг ашиглах нөхцөлд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Галуут” 110/35/6 кВт-ын дэд станцад шугамын утсыг АС240 маркаар солих 3. 2 x 16000 кВа-ын трансформатор нэмж суурилуулах 4. Төмөр замын дутуу рельсүүдийг нөхөн тавьж сэргээх 5. Хүнд үйлдвэрийн бүсээс төмөр замын 9 м өндөр тунель хүртэл 300 м газарт авто зам тавьж орох гарах үндсэн гарц байгуулах 6. Бүсийн дотоод дэд бүтцүүдийг батлагдсан зураг төслөөр шат дараатай байгуулах <p>Дээрх асуудлыг НЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх саналыг НЦУУИГ-т уламжлан хүргүүлсэн боловч одоогоор ямар нэгэн шийдвэр ирүүлээгүй байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2019.06.21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар паркад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл хийлгэх 65 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр нарийвчилсан үнэлгээг “Санни трейд” ХХК-аар гүйцэтгүүлэн, 2020.02.03-ны өдөр, барилгын зураг төслийг “Нутаг консалтинг” ХХК-аар гүйцэтгүүлж 2020.07.20-ны өдөр актаар хүлээн авсан.</p>	
Жилийн эцсийн дүн	100%		

ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА